

ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах үүднээс удирдах албан тушаалтны ажлын байр түр болон урт хугацаанд эзэнгүй болох орон тоо гэнэт өөрчлөгдсөнөөс үүдэн гарах эрсдэлийг удирдахын тулд эрх бүхий албан тушаалтан болон эрх бүхий албан тушаалтнаас бусад хэлтсийн захирал, салбарын захирал, ерөнхий нягтлан бодогчийн залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.2 Байгууллагын эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнуудыг ойлгоно. Үүнд:
 - 1.2.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
 - 1.2.2 Гүйцэтгэх захирал
 - 1.2.3 Зээлийн удирдлагын хэлтсийн захирал
 - 1.2.4 Ерөнхий нягтлан бодогч

Хоёр. Залгамж халааны төлөвлөгөө

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид “Хороо” гэх/ байгуулан ажиллана.
- 2.2 Хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ батална.
- 2.3 Хороо нь эрх бүхий албан тушаалтан томилох нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно.
- 2.4 Эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хөгжүүлж, үнэлж, дүгнэх замаар бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5 Эрх бүхий албан тушаалтнаас бусад хэлтсийн захирал, салбарын захирал, нягтлан бодогчийн залгамжлах нэр дэвшигчийг Гүйцэтгэх захирал тодорхойлох, өөрчлөх, томилох ба судалгаа хийнэ.
- 2.6 Гүйцэтгэх захирал нь ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргах бөгөөд албан тушаал дэвшин ажиллах боломжтой, чадварлаг ажилтнуудыг тодорхойлж, ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.7 Бизнесийн хэрэгцээ шаардлагаар хэлтэс, салбаруудын орон тоог Гүйцэтгэх захирал санал болгож, ТУЗ-ийн шийдвэрээр батална.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхэд хяналт тавьж дүгнэлт гаргаж ажиллана.
- 3.2 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гарган, ТУЗ-д танилцуулна.
- 3.3 Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдлыг тогтоох тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.

Дөрөв. Залгамж халааг бэлтгэх

- 4.1 Эрх бүхий албан тушаалтны залгамж халааны төлөвлөгөө